

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй:

1/16.12 дугаар зүйл:

“16.12 дугаар зүйл.Хүүхдийг мансуурах байдалд татан оруулах

1.Хүүхдийг байнгын мансуурах, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий байдалд татан оруулсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн, эсхүл энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

2/20.20-20.29 дүгээр зүйл:

**20.20 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль
бусаар олж авах, бэлтгэх, боловсруулах, хадгалах,
тээвэрлэх, илгээх, дамжуулах, худалдах, худалдан
авах, шилжүүлэх, зуучлах, захиалах**

1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авсан, бэлтгэсэн, боловсруулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, дамжуулсан, худалдсан, худалдан авсан, бусдад шилжүүлсэн, зуучилсан, эсхүл экспортлох, импортлох зорилгоор захиалсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

- 2.1.байнга тогтвортой;
- 2.2.бүлэглэж;
- 2.3.албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж;
- 2.4.хүүхэд, эсхүл өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй хүнийг оролцуулж;
- 2.5.их хэмжээгээр;
- 2.5.олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.зохион байгуулалттай гэмт бүлэг;

3.2.онц их хэмжээгээр үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ хуульд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын “их хэмжээ”, “онц их хэмжээ”, мөн мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлын “их хэмжээ”, “онц их хэмжээ”-г Монгол Улсын Засгийн газар тогтооно.

-Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзаж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эрх бүхий байгууллагад сайн дураараа шилжүүлэн өгсөн, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй тусалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн этгээд, бүлэглэлийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлэхэд тусалсан хүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг мөрдөн шалгах ажиллагааны явцад илрүүлж хураан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй.

20.21 дүгээр зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд оролцох

1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулахыг мэдсээр байж тоног төхөөрөмж, эд зүйлсийг бэлтгэн өгсөн, нийлүүлсэн, түгээсэн, эсхүл санхүүжүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.байнга тогтвортой;

2.2.бүлэглэж;

2.3.албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж;

2.4.хүүхэд, эсхүл өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй хүнийг оролцуулж;

2.5.ашиг олох зорилгоор үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзаж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эрх бүхий байгууллагад сайн дураараа шилжүүлэн өгсөн, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн этгээд, бүлэглэлийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлэхэд тусалсан хүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг мөрдөн шалгах ажиллагааны явцад илрүүлж хураан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй.

20.22 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах, хэрэглэхэд орон байр, тээврийн хэрэгслээр хангах

1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах, эсхүл хэрэглэхийг мэдсээр байж орон байр, барилга байгууламж, тээврийн хэрэгслээр хангасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг байнга тогтвортой үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

20.23 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж завшсан бол хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.байнга тогтвортой;

2.2.бүлэглэж;

2.5.их хэмжээгээр үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.зохион байгуулалттай гэмт бүлэг;

3.2.онц их хэмжээгээр үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

20.24 дүгээр зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эргэлтэд оруулах хууль, журам зөрчих

1.Хуульд заасан зөвшөөрөл авсан, эсхүл хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актаар үүрэг хүлээсэн этгээд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эргэлтэд оруулахад дагаж мөрдөх хууль тогтоомж зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж, таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.байнга тогтвортой;

2.2.бүлэглэж;

2.3.ашиг олох зорилгоор үйлдсэн;

2.4.уг гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан бол мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж, хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан бол мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж, хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж, таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

20.25 дугаар зүйл.Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг хууль бусаар тарималжуулах, түүх

1.Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг хууль бусаар тарималжуулсан, эсхүл түүсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.байнга тогтвортой;

2.2.бүлэглэж;

2.3.албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж;

2.4.ургах нөхцөлийг бүрдүүлэх, үржүүлэх, ургуулах тусгайлсан орчин бий болгож, нутагшуулж, хүлэмж хэлбэрээр улирал харгалзахгүй ургуулж;

2.5.хүүхэд, эсхүл өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй хүнийг оролцуулж үйлдсэн;

2.6.ашиг олох зорилгоор;

2.7.их хэмжээгээр үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.зохион байгуулалттай гэмт бүлэг;

3.2.онц их хэмжээгээр үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тайлбар:-Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзаж мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг хураан авахаас өмнө сайн дураар устгасан, эсхүл мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн этгээд, бүлэглэлийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлсэн хүний ялыг хөнгөрүүлэх, эсхүл ялаас чөлөөлж болно. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг мөрдөн шалгах ажиллагааны үед устгасныг сайн дураараа устгасанд тооцохгүй.

20.26 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдах

1.Хуульд заасан журмаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг худалдах тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд бусдад хууль бусаар худалдсан бол найман жил хүртэл хугацаагаар эрх хасаж, хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.байнга тогтвортой;

2.2.бүлэглэж;

2.3.хүүхэд, эсхүл өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй хүнийг оролцуулж үйлдсэн;

2.4.их хэмжээгээр үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн;

3.2.онц их хэмжээгээр үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзаж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эрх бүхий байгууллагад сайн дураараа шилжүүлэн өгсөн, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн этгээд, бүлэглэлийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлэхэд тусалсан хүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг мөрдөн шалгах ажиллагааны явцад илрүүлж хураан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй.

20.27 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх

1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хуульд заасан зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн, эсхүл зөвшөөрөлд заасан тоо, хэмжээг хэтрүүлсэн, зөвшөөрөлд заасан нэр төрөл, цувралын дугаар зөрүүлж улсын хилээр нэвтрүүлсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

- 2.1.байнга тогтвортой;
- 2.2.бүлэглэж;
- 2.3.албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж;
- 2.4 хүүхэд, эсхүл өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй хүнийг оролцуулж үйлдсэн;

2.5 их хэмжээгээр үйлдсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

- 3.1.зохион байгуулалттай гэмт бүлэг;
- 3.3.онц их хэмжээгээр үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзаж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эрх бүхий байгууллагад сайн дураараа шилжүүлэн өгсөн, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн этгээд, бүлэглэлийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлэхэд тусалсан хүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг мөрдөн шалгах ажиллагааны явцад илрүүлж хураан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй.

20.28 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар үйлдвэрлэх

1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар үйлдвэрлэсэн, гарган авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.байнга тогтвортой;
2.2.бүлэглэж;
2.3.албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж;
2.3.хүүхэд, эсхүл өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй хүнийг оролцуулж үйлдсэн;

2.4.их хэмжээгээр үйлдсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.зохион байгуулалттай гэмт бүлэг;
3.2.онц их хэмжээгээр үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзаж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эрх бүхий байгууллагад сайн дураараа шилжүүлэн өгсөн, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн этгээд, бүлэглэлийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлэхэд тусалсан хүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг мөрдөн шалгах ажиллагааны явцад илрүүлж хураан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй.

20.29 дүгээр зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бусдад хэрэглэх, бусдад хэрэглүүлэх

1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бусдад хэрэглэсэн, эсхүл бусдад хэрэглүүлсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.байнга тогтвортой;
2.2.бүлэглэж;
2.3.албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж;
2.4.бусдад хүч хэрэглэж;
2.5.хүүхдийг оролцуулж, уруу татаж, өдөөн турхирч, хууран мэхэлж;

2.6.их хэмжээгээр;

2.7.өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй хүнийг оролцуулж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.зохион байгуулалттай гэмт бүлэг;

3.4.хорих ял эдлүүлэх газар, сургалтын байгууллагад үйлдсэн;

3.5.онц их хэмжээгээр үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзаж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг эрх бүхий байгууллагад сайн дураараа шилжүүлэн өгсөн, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн этгээд, бүлэглэлийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлэхэд тусалсан хүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг мөрдөн шалгах ажиллагааны явцад илрүүлж хураан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй.

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 6.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “20.7/Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/” гэснийг “20.20/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авах, бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, илгээх, дамжуулах, худалдах, худалдан авах, шилжүүлэх, зуучлах, захиалах/, 20.21/ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд оролцох/, 20.26/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдах/, 20.29/ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бусдад хэрэглэх, бусдад хэрэглүүлэх/” гэж, 6.15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “эсхүл, хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэргийг” гэснийг “хүнд гэмт хэргийг” гэж, 7.3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтын “мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж, 27.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “мансууруулах бодис” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 16.2 дугаар зүйлийн гарчиг болон 1 дэх хэсгийн “мансуурах,” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 20.7, 20.8, 20.9, 20.10 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/13.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалт:

“1.3.Эрх бүхий байгууллагад ил болоогүй, бусдын үйлдсэн хүнд гэмт хэргийн талаар үнэн бодит мэдээлэл өгч гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлэх, эрх бүхий байгууллагатай хамтран ажиллахаа илэрхийлсэн бол.”

2/13.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.8 дахь заалт:

“5.8.хамтран ажиллах этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаарх санал.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын “нөхцөл” гэсний дараа “, хамтран ажиллах этгээдийн үүрэг” гэж, 34.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх,” гэсний дараа “ ялыг хөнгөрүүлэх,” гэж, 43.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “гарсан” гэсний дараа “, гадаад улсын нутаг дэвсгэрээс Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/13.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:

“9.Шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах этгээдэд болон түүний хамаарал бүхий этгээдэд энэ хуулийн 13.2 дугаар зүйлд заасан хамгаалалтын арга хэмжээ авна.”

2/13.5 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг:

“8.1.хамтран ажиллах этгээд энэ хуулийн 13.5 дугаар зүйлийн 8.2-т заасан нөхцөлийг хангаж, үүргээ биелүүлсэн тохиолдолд түүний үйлдсэн гэмт хэрэгт нь оногдуулах Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, эсхүл ялыг хөнгөрүүлэх талаар;”

4 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтын “20.7 дугаар зүйлийн 3.3-т” гэснийг “20.26/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдах/ дугаар зүйл, 20.27/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр

нэвтрүүлэх/ дүгээр зүйл, 20.28/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар үйлдвэрлэх/ дугаар зүйл” гэж, 13.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалт, 14.13 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн 11.2 дахь заалтын “20.7 /Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/” гэснийг “20.20/ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авах, бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, илгээх, дамжуулах, худалдах, худалдан авах, шилжүүлэх, зуучлах, захиалах/ дугаар зүйл, 20.25/ Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг хууль бусаар тарималжуулах, түүх/ дугаар зүйл, 20.26/ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдах/ дугаар зүйл, 20.27/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх/ дугаар зүйл, 20.28/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар үйлдвэрлэх/ дугаар зүйл, 20.29/ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бусдад хэрэглэх, бусдад хэрэглүүлэх/ дүгээр зүйл” гэж, 26.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг/Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 20.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах/, 20.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах/” гэснийг “20.20/ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авах, бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, илгээх, дамжуулах, худалдах, худалдан авах, шилжүүлэх, зуучлах, захиалах/ дугаар зүйл, 20.25/Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг хууль бусаар тарималжуулах, түүх/ дугаар зүйл, 20.26/ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдах/ дугаар зүйл, 20.27/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх/ дугаар зүйл, 20.28/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар үйлдвэрлэх/ дугаар зүйл, 20.29/ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бусдад хэрэглэх, бусдад хэрэглүүлэх/ дүгээр зүйл” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд дор дурдсан агуулга бүхий хэсэг нэмсүгэй:

1/5.1 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:

“3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалтад ороогүй эм, бодис, бусад зүйлсийг урвуулан хэрэглэж мансуурсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, эсхүл албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчилна.

4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж мансуурсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж 30 хоногийн хугацаагаар баривчилна.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6.4 дүгээр зүйл:

“6.4 дүгээр зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хууль тогтоомж зөрчих

1.Зөвшөөрөл эзэмшигч, эсхүл хууль тогтоомжийн дагуу үүрэг хүлээсэн этгээд үйл ажиллагаа явуулах байршилд орсон өөрчлөлтийг хуульд заасны дагуу мэдэгдээгүй бол хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хадгалах, бүртгэх, хуваарилах, тээвэрлэх, улсын хилээр нэвтрүүлэх, устгахтай холбоотой хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Зөвшөөрөл эзэмшигч, эсхүл хууль тогтоомжийн дагуу үүрэг хүлээсэн этгээд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбоотой тайлан, мэдээллийг хуульд заасны дагуу гаргаж өгөөгүй, мэдээллийн санд холбогдох мэдээллийг оруулаагүй бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Тариалангийн газрын эзэмшигч, ашиглагч тухайн газарт болон хуульд заасан бусад талбайд ургасан мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй

ургамлыг устгах үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн угтвар бодисыг бэлтгэх, боловсруулах, үйлдвэрлэх, хэрэглэх, тарималжуулахыг сурталчилсан, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээний талаар агуулга бүхий кино, тоглолт, дуу, дүрс бичлэг, ном, товхимол, зураг болон бусад бүтээл туурвисан, түгээсэн, борлуулсан, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нэр, зураг, дүрс, тэмдгийг бараа бүтээгдэхүүн, түүний хаяг, шошго, сурталчилгаанд ашигласан, мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар хэрэглэхийг олон нийтэд уриалсан бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2/4.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Албадан сургалт 3-30 хоногийн хугацаатай байх бөгөөд сургалтын цаг нь хоногт 5 цагаас хэтрэхгүй байна.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 4.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “шийдвэрлэж болно” гэснийг “шийдвэрлэнэ” гэж, 9.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь заалтын “мансууруулах бодис” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэж, 10.13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.2 дахь заалтын “хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх, борлуулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бус эргэлтэд оруулах” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “мансуурсан” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.8 дахь заалтын “6.3 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг,” гэсний дараа “6.4 дүгээр зүйл, ” гэж, 6.14 дэх заалтын “6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэсний дараа “6.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, ” гэж, 6.46 дахь заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “6.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг,” гэж, 6.50 дахь заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “6.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.57 дахь заалтын “6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дахь хэсэг,” гэснийг “6.6 дугаар зүйл” гэж, тус зүйлийн 7 дахь хэсэг, тус зүйлийн 9 дэх хэсгийн “5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг” гэснийг “5.1 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг” гэж , 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг” гэснийг “5.1 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/1.32 дахь заалт

1.32.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар түүх	Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага
--	---

2/12.15-12.19 дахь заалт:

12.15.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис агуулсан мал, амьтны эм, эмийн түүхий эд үйлдвэрлэх	Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
12.16.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис агуулсан мал, амьтны эм, эмийн түүхий эд импортлох, реэкспортлох	Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
12.17.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис агуулсан мал, амьтны эм, эмийн түүхий эд экспортлох	Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
12.18.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис агуулсан мал, амьтны эм, эмийн түүхий эд ханган нийлүүлэх	Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
12.19.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ашиглан мал, амьтанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх	Тухайн аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар

3/13.21-13.25 дахь заалт

13.21.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан, хүнд зориулсан эм, эмийн түүхий эд үйлдвэрлэх	Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
13.22.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан, хүнд зориулсан эм, эмийн түүхий эд импортлох-реэкспортлох	Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
13.23.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан, хүнд зориулсан эм, эмийн түүхий эд ханган нийлүүлэх	Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
13.24.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан, хүнд зориулсан эм,	Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

худалдах, олгох эмийн сангийн үйлчилгээ эрхлэх	
13.25.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан, хүнд зориулсан эм, эмийн түүхий эд тээвэрлэх	Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

2 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “ашиглахад” гэснийг “ашиглах, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй холбоотой” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13 дахь хэсгийн 13.17, 13.18 дахь заалтын “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм” гэснийг, 13.19 дэх заалтын “, мансууруулах эм” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг:

“3.2.Зөвшөөрөлтэй холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.1.5 дахь заалт:

“4.1.4.”мансууруулах эм” гэж “Мансууруулах эмийн тухай” Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1961 оны конвенц, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд заасан жагсаалтад орсон бодисыг эмчилгээний тунгаар агуулсан эмийг;

4.1.5.”сэтгэцэд нөлөөт эм” гэж “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1971 оны конвенц, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд заасан жагсаалтад орсон бодисыг эмчилгээний тунгаар агуулсан эмийг;”

2/28 дугаар зүйл:

“28.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, урвуулан ашиглах эрсдэлтэй эмийн жагсаалтыг батлах бөгөөд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан жагсаалтыг үндэслэнэ.

28.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм үйлдвэрлэх, импортлох, экспортлох, реэкспортлох, худалдах буюу ханган нийлүүлэх, үйлчлэх, эмийн сангаас олгох, хадгалах, устгах, тээвэрлэх үйл ажиллагаатай холбогдох энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар зохицуулна.

28.3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн эргэлттэй холбогдох зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон энэ хуулиар зохицуулснаас

бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар зохицуулна.

28.4.Эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний лавлагаа лаборатори нь мансууруулах эмийн дээж, сэтгэцэд нөлөөт эмийн дээж, урвуулан ашиглах эрсдэлтэй эмийн дээж, тэдгээрийн түүхий эдийн дээж, стандарт бодисыг судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглаж, хадгалж болно.

3 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8 дугаар зүйл 8.5 дахь хэсэг:

“8.5.Энэ хуулийн 8.1.24-т заасан үйл ажиллагааг зохион байгуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2/19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг:

“19.3.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь чиглэлээр олгоно:

19.3.1.эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх;

19.3.2.эм, уламжлалт эм, биобэлдмэл, тэдгээрийн түүхий эд, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх-экспортлох;

19.3.3.эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх-реэкспортлох;

19.3.4.эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах, олгох;

19.3.5.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх;

19.3.6.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис импортлох, реэкспортлох;

19.3.7.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис экспортлох, реэкспортлох;

19.3.8.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис ханган нийлүүлэх;

19.3.9.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан эм худалдах, олгох эмийн сангийн үйлчилгээ эрхлэх;

19.3.10.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх;

19.3.11.эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх;

19.3.12.ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх;

19.3.13.ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис худалдах болон үйлчилгээ эрхлэх.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МАЛ, АМЬТНЫ ЭМ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйл 4.1.12, 4.1.13 дахь заалт:

"4.1.12."мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эм" гэж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис агуулсан, мал, амьтны эм, эмийн түүхий эдийг;

4.1.13."мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис" гэж олон улсын гэрээ болон Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан жагсаалтад орсон бодисыг."

2 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн "бөөнөөр ханган нийлүүлэх" гэсний дараа "тусгай зөвшөөрөл бүхий" гэж, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн "тусгай зөвшөөрөл бүхий" гэсний дараа "ханган нийлүүлэх байгууллага," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/16 дугаар зүйл:

"16 дугаар зүйл.Мал, амьтны эмнэлэгт хэрэглэх мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн зохицуулалт

16.1.Мал, амьтны эмнэлэгт хэрэглэх мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм (цаашид "мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эм" гэх)-ийн жагсаалтад орсон эмийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно.

16.2.Мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн жагсаалтад орсон эмийг мал, амьтанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд ашиглах тусгай зөвшөөрлийг тухайн аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар олгоно.

16.3.Мал эмнэлгийн байгууллага нь мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт, хэрэглээний тайланг хуульд заасан хугацаанд гарган хуульд заасан эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

16.4.Мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн жилийн тайланг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны

байгууллага нь хуульд заасан хугацаанд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн төв байгууллагад хүргүүлнэ.

16.5.Мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт, хэрэглээний явцад мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хяналт тавина.

16.6.Мал эмнэлгийн байгууллагад хэрэглэсэн мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн орлого, зарлага, устгалын бүртгэл хөтлөх, зарцуулалтын журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.7.Мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар зохицуулна.”

2/17 дугаар зүйлийн 17.1:

“17.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12.12, 12.15, 12.16-д заасан тусгай зөвшөөрөл, 8.2 дугаар зүйлийн 11.4-т заасан энгийн зөвшөөрлийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 8.1 дүгээр зүйлийн 12.17-д заасан тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар тус тус олгоно.”

4 дүгээр зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.3, 17.4 дэх хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуульд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд” гэж, 17.7 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулиар” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.5 дахь заалт нэмсүгэй:

“4.1.5. “хамтран ажиллах этгээд” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийг.”

2 дугаар зүйл. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн “хүний эрхийн хамгаалагчийн” гэсний өмнө “хамтран ажиллах этгээд,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³ дүгээр зүйлийг дор дурдснаар өөрчлөн найруулсугай:

“21³ дугаар зүйл.Согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг дэмжих сан

21³.1.Согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг дэмжих сан нь согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай байна.

21³.2.Тус сангаас дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ:

21³.2.1.согтуурах, мансуурах, донтолтын хор хөнөөлийг насны онцлогт тохируулан холбогдох арга зүйн дагуу таниулах арга хэмжээ;

21³.2.2.донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ явуулах, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий хүнд эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, донтох эмгэгийн сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэх төв, бусад байгууллагын үйл ажиллагаа, барилга байгууламж, хүний нөөц, шаардлагатай бусад хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүлэх;

21³.2.3.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд авах албадан сургалтын арга хэмжээнд шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

21³.2.4.донтох эмгэгтэй, төлбөрийн чадваргүй, сайн дураар эмчлүүлэх хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээнд шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

21³.2.5.донтох эмгэгтэй хүнд авах албадан эмчилгээний арга хэмжээнд шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

21³.2.6.согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх, тэмцэх бусад үйл ажиллагаа;

21³.2.7.согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын зардлын төлбөрийн 50 хувийг.

21³.3.Онцгой албан татварын тухай хуулийн 6.11-д заасны дагуу ногдуулан хураасан татварын орлогын гүйцэтгэлээс татвар ногдсон согтууруулах ундааны литр тутам хамаарах 300 төгрөгийн орлогыг Согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг дэмжих санд тухай бүр төвлөрүүлнэ.

21³.4.Энэ хуулийн 21³.3-т заасны дагуу онцгой албан татварын орлогын гүйцэтгэлээс Согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг дэмжих санд хөрөнгө төвлөрүүлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

21³.5.Согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг дэмжих сангийн хөрөнгийг энэ зүйлд заасан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

21³.6.Согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг дэмжих сангийн дүрэм, Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журам болон уг сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон журмыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.25 дахь заалтын “Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх” гэснийг “Согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх, тэмцэх” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН
СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“33 дугаар зүйл. Согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг дэмжих сан

33.1. Согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг дэмжих сан /цаашид "сан" гэх/-гийн хөрөнгөөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³ дугаар зүйлд заасан дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ:

33.1.1. согтуурах, мансуурах, донтолтын хор хөнөөлийг насны онцлогт тохируулан холбогдох арга зүйн дагуу таниулах арга хэмжээ;

33.1.2. донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ явуулах, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий хүнд эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, донтох эмгэгийн сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаа, барилга байгууламж, хүний нөөц, шаардлагатай бусад хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүлэх;

33.1.3. согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд авах албадан сургалтын арга хэмжээнд шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

33.1.4. донтох эмгэгтэй, төлбөрийн чадваргүй, сайн дураар эмчлүүлэх хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээнд шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

33.1.5. донтох эмгэгтэй хүнд авах албадан эмчилгээний арга хэмжээнд шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

33.1.6. согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх, тэмцэх бусад үйл ажиллагаа;

33.1.7. согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын зардлын төлбөрийн 50 хувийг;

33.1.8. энэ хуулийн 33.3-т заасан Сангийн ажлын албаны үйл ажиллагаа, албан хаагчийн цалин хөлсний зардлыг санхүүжүүлэх.

33.2.Сан нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллах бөгөөд сангийн ажлын алба хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.

33.3.Сангийн Ажлын албаны төсөв, бүтэц, орон тоог хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

33.4.Сан нь Удирдах зөвлөлтэй байх бөгөөд Удирдах зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ахална.

33.5.Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллага, Засгийн газрын бус байгууллагын төлөөллийг тэнцүү тоогоор оролцуулна.

33.6.Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25.5-д заасан хяналтын хороо хяналт тавих бөгөөд уг хорооны бүрэлдэхүүнд олон нийтийн төлөөлөл нь гуравны хоёроос доошгүй байна.

33.7.Энэ хуулийн 33.6-д заасан төлөөлөлд согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг төлөөлөх ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөлөл гуравны нэгээс доошгүй байна.

33.8.Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр****Улаанбаатар
хот****ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд дараах хэсэг нэмсүгэй:

1/14 дүгээр зүйлийн 14.5, 14.6 дахь хэсэг:

“14.5.Зохицуулах зөвлөлийн Ажлын албанд төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагаас сэлгэн болон шилжүүлэн томилогдсон алба хаагч нь тусгай чиг үүрэгтэй холбоотой тухайлсан хуулиар зохицуулсан нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангагдана.

14.6.Зохицуулах зөвлөлийн Ажлын албаны бүтэц, орон тоо, дүрмийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дараах зүйл, хэсгийг дор дурдснаар өөрчлөн найруулсугай:

1/14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг:

“14.4.Зохицуулах зөвлөл, салбар зөвлөлийн орон тооны ажлын албаны алба хаагч нь төрийн алба хаагч байх бөгөөд тус алба хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2/46 дугаар зүйл:

“46 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт

46.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.2, 5.3 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.5, 5.6, 5.7 дугаар зүйл, 5.8 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг, 5.9 дүгээр зүйл, 5.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.11 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, 4, 6 дахь хэсэг, 5.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 5.16, 5.18 дугаар зүйл, 6.3 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.4 дүгээр зүйл, 6.5 дугаар зүйлийн 1, 4, 5, 11, 12, 13 дахь хэсэг, 6.18 дугаар зүйлийн 4, 7 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 4, 5, 7, 9 дэх хэсэг, 6.21, 6.22 дугаар зүйл, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 8.8 дугаар зүйл, 10.4, 10.8, 10.26, 10.28 дугаар зүйл, 11.15 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 13.5, 14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7, 15.1 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.18 дугаар зүйл, 15.20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.21 дүгээр зүйл, 15.22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг

биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 30-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэрэг, зөрчил, донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг таниулах арга хэмжээ болон донтох эмгэгийн сэргээн засах эмчилгээ, тусламж, үйлчилгээний үйл ажиллагаа, барилга байгууламжид дэмжлэг үзүүлэхэд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

46.2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт нь энэ хуулийн 46.1-д зааснаас гадна хуулиар хориглоогүй бусад санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдэнэ.

46.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг хууль зүйн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн болон аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь тус тус нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Салбар зөвлөл, гэмт хэргийн нөхцөл байдал, цаашдын төлөвийг харгалзан хуваарилж, зарцуулна.

46.4.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

46.5.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна:

46.5.1.гэмт хэрэг, донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг таниулах талаар хууль сахиулах болон Засгийн газрын бус байгууллага, иргэнээс зохион байгуулж байгаа сургалт, сурталчилгааны ажлын зардалд дэмжлэг үзүүлэх;

46.5.2.донтох эмгэгийн сэргээн засах эмчилгээ, тусламж, үйлчилгээний үйл ажиллагаа, барилга байгууламжид дэмжлэг үзүүлэх;

46.5.3.энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлж яваад эрүүл мэндээрээ хохирсон буюу амь насаа алдсан тохиолдолд түүнд болон ар гэрт нь олгох тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх;

46.5.4.гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд болон шүүхийн шинжилгээний байгууллагаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардалд дэмжлэг үзүүлэх;

46.5.5.гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг иргэдээс авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх;

46.5.6.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үнэлгээ, судалгаа хийх, тэдгээрийг хэлэлцүүлэх, хуульд заасан дүрэм, журам, заавар боловсруулахад дэмжлэг үзүүлэх;

46.5.7.тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга, ажиллагааны талаарх судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх;

46.5.8.олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардлыг санхүүжүүлэх;

46.5.9.энэ хуулийн 14.2-т заасан Зохицуулах зөвлөлийн орон тооны ажлын албаны үйл ажиллагаа, албан хаагчийн цалин хөлс, Салбар зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргын цалин хөлсний зардлыг санхүүжүүлэх;

46.5.10.авто замын тэмдэг, тэмдэглэлийг шинээр байршуулах, шинэчлэх, засварлах;

46.5.11.энэ хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг шагнаж, урамшуулах;

46.5.12.хууль тогтоомжид заасан бусад.

46.6.Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хөрөнгийг зөрчлийн нөхцөл байдал, цаашдын төлөв байдлыг харгалзан асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тухай бүр тусгаж, зарцуулна.

46.7.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

46.8.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад Зохицуулах зөвлөл, төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.10 дахь заалтын “хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

\

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн 20 дугаар зүйлийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйл. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамал

“20 дугаар зүйл. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамал

1. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг эрдэм шинжилгээ, судалгааны зориулалтаар түүх зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг тодорхойлоход Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд заасны дагуу Засгийн газраас баталсан жагсаалтыг баримтална.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдох энэ хуульд зааснаас бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хууль болон Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд заасны дагуу зохицуулна.

4. Хуульд зааснаас бусад тохиолдолд хүн, хуулийн этгээд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг түүх, ашиглах, тарималжуулахыг хориглоно.

5. Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамалд энэ хуулийн Гуравдугаар бүлэг хамаарахгүй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 246 дугаар зүйлийн 246.5.1 дэх заалтын “нөлөөт эм” гэснийг “нөлөөт бодис, тэдгээрийн угтвар бодис,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“37.1.4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтын “мансууруулах бодис” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гэр бүлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.1 дэх заалт, 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.1.4 дэх заалт, 68 дугаар зүйлийн 68.1.3 дахь заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсгийн “мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5/согтуурсан, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн болон сэтгэцийн өвчтэй хүмүүсийг жагсаал, цуглаанд оролцуулахгүй байх, жагсаал, цуглааны явцад согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлэхгүй байх;”

2 дугаар зүйл. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын “мансууруулах болон хорт бодис” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Жолоочийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсгийн “мансууруулах бодис” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтын “мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр**

**Улаанбаатар
хот**

**ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зар сурталчилгааны тухай хуулийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2.4 дэх хэсэг нэмсүгэй:

“2.4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой мэдээ, мэдээлэлд хяналт тавих, хууль бус сурталчилгааг хориглохтой холбогдсон харилцааг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Зар сурталчилгааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсгийн дугаарыг 2.5 гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалтын “хар тамхи, мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ОРДНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын төрийн ордны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалтын “мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нотариатын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

СОГТУУРУУЛАХ УНДАА ХЭТРҮҮЛЭН ХЭРЭГЛЭСЭН ЭТГЭЭДИЙГ АЛБАДАН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн “мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл,” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж, тус зүйлийн 8.8.2 дахь заалтын “мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтын “согтууруулах болон мансууруулах ундааны зүйлийг” гэснийг “согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.9 дэх заалтын “мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Усан замын тээврийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2 дахь заалтын “мансууруулах үйлчилгээтэй эм,” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРЬЯАТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Харьяатын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын “мансууруулах бодис хэрэглэх донтой,” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр****Улаанбаатар
хот****ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, 38 дугаар зүйлийн 38.1.8 дахь заалтын “мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж, 25 дугаар зүйлийн 25.5.4 дэх заалт, 25.7.3 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.1.7 дахь заалт, 31.4.3 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.3.1 дэх заалт, 46 дугаар зүйлийн 46.5.5 дахь заалт, 52 дугаар зүйлийн 52.1.6 дахь заалтын “мансууруулах эм” гэснийг “мансууруулах” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шуудангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“24.1.3.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 164 дүгээр зүйлийн 164.6 дахь хэсгийн “мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж, 272 дугаар зүйлийн 272.1.3 дахь заалтын “мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тариалангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “хар тамхи, мансууруулах” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН
ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг, 42 дугаар зүйл, заалтуудыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл.Засгийн газар Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан жагсаалт, ангилал, 10 дугаар зүйлд заасан жагсаалтыг энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш 3 сарын дотор батална.

3 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш 1 жилийн хугацаанд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12 дугаар зүйлд тавигдах шаардлагыг хангаж, 13 дугаар зүйлд заасан бүрдүүлэх баримт бичгийг бүрдүүлнэ.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ